



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар Д/661

Хэрлэн сум

Шагнаж урамшуулахад
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Хорьдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймагт хэрэгжүүлэх “Гучин сая мод” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны төлөвлөгөөт ажлыг хангалттай сайн биелүүлж ажилласан сумдыг шагнаж, урамшуулахад 4,690,000 (дөрвөн сая зургаан зуун ерин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шагнагдах сумдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах хөрөнгийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын төвлөрсөн дансны Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 22-ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Шагнагдах сумдын нэрс

1. Цэнхэрмандал сум
2. Баян-Адрага сум
3. Биндэр сум
4. Мөрөн сум
5. Галшар сум
6. Бор-Өндөр сум
7. Баянмөнх сум



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 12-ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Зарцуулах хөрөнгийн тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Батламж	7	20,000	140,000
2	Баярын бичиг	7	50,000	350,000
3	Мөнгөн шагнал	7	600,000	4,200,000
				4,690,000